

"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК-НИЙН ХАГАС ЖИЛИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК, 9007001003, MSE:TNGR 95432111	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хэвлэл мэдээлэл, контент үйлдвэрлэл	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	"ХҮЛЭГТХҮННУ АУДИТ" ХХК СЗХ-ны 2014 оны 06-р сарын 25-ны өдрийн 222-р тогтоол	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	6,000,000	
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Халиунгоо Хянасан: Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ	
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	<u>Тайланг хавсаргав</u>
	Орлогын тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
	Мөнгөн гүйлгээний тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	<u>Аудитын дүгнэлтийг хавсаргав</u>	
1.2	Аудитын тодорхойлолх захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	<u>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.</u>	
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд Ашигт ажиллагаа	
2.2.	Хөрвөр чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) -0.017 Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) -0.020 Өөрчлөлтийн хувь /оны эхээс/ Нийт активын өөрчлөлт 0.0052 Зээлийн багцын өөрчлөлт *Тайлант хугацаанд зээл олгоогүй. Харин хараат компаниудад хөрөнгө оруулсан. Хөрөнгөд эзлэх хувь Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө 81% Өр төлбөр/Нийт хөрөнгө 19% Хөрвөх чадварын харьцаа Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө/ 0.25	
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2021 онд Тэнгэрлиг Медиа Групп ХК нь хараат компани Ори Студиос ХХК болон охин компани Про Медиа Нетворк ХХК-ийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалт хийх зорилгоор байсан 58,543 ширхэг хувьцаан дээр нэмээд 5,941,457 ширхэг хувьцаа гаргасан. Ори Студиос ХХК-ийн хувьд зах зээлд дөнгөж үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа боловч олон шинэ төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. 2025 оны эхний улиралд тус компани нь Ори Студиос төслийн эхний блокийг амжилттай ашиглалтад оруулж комист хүлээлгэж өгснөөр орлого олох боломж нээгдсэн. Үүний зэрэгцээ, Про Медиа Нетворк ХХК нь телевизийн контентийн зах зээлд аль хэдийн байр сууриа эзэлсэн бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулсаар, шинэлэг контент төслүүдийг амжилттай хэрэгжүүлсээр байна. Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн зүгээс эдгээр өөрчлөлтөд нийцүүлэн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй ашиглах, шинэ төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх чиглэлд анхаарч, хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулах, зах зээлд байр сууриа бэхжүүлэх стратеги боловсруулан ажиллаж байна.	
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй	
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Ард Актив-ийн зээл Хаасан: 2021 онд Тэнгэрлиг Медиа ХК-нь "Ард Актив" ХЗХ-с 1,430,000,000 төгрөгийн зээл авч байсан бөгөөд 2022 онд нэмж 184,500,000 төгрөгийн зээл авсан. Зээлийн нийт дүн 1,614,500,000₮. Тухайн зээлийг 61,638,000.00 ширхэг ардкойн (тухайн үеийн зах зээлийн ханш болох 58 төгрөг) барьцаалж авсан. Хөрөнгө оруулалтын гэрээг дахин шинэчилж олгосон зээлийг хөрөнгө оруулалт гэж үзээд гэрээгээ дахин	

		шинэчлээд Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн хувьцаагаар зээлийг хаасан. Ори Студиос ХХК-ийн зээл Хаасан: 2023 онд Ори Студиос ХХК нь Ард Кредит-ээс 900 сая төгрөгийн зээлийг Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн 230,000 ширхэг хувьцааг (тухайн үеийн ханш 10,000) барьцаалж авсан. Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Ори Студиос ХХК-ийн зээлийг Тэнгэрлиг Медиа Групп Ард Койноор эргэн төлсөн.
--	--	---

3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
	2021 онд байгуулагдсан хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн үнэ цэнэ буурсан нь гэрээнд тодорхой өөрчлөлт оруулсан. Үүний дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг дахин үнэлж, тэдгээрийн үнэлгээтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн. Энэхүү өөрчлөлт нь компанийн хамгийн том хувьцаа эзэмшигчдийн хооронд хийсэн хэлцлийн үр дүн юм.
4.	Цалин урамшууллын мэдээлэл
	2024 онд ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгоогүй. Гүйцэтгэх удирдлагад 151.010.862.76 сая төгрөгийн цалингийн 127,290,633.35 төгрөгийг өглөгт тооцсон..
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл; Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
	2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭ-24/02 тоот тогтоолоор дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд томилсон. Үүнд: Ердийн гишүүд: Г.Уянга(хурлын дарга), Н.Мөнхнасан, Ч.Батхүү, А.Ундрал, Б.Золбоо, Г.Бат-Эрдэнэ Хараат бус гишүүд: Б.Наранзун, Б.Гантулга, В.Ганзориг Б.Гантулга гишүүнийг 24/08 тоот тогтоолоор чөлөөлж, Ж.Алтангүнийг түр томилсон. Компанийн эцсийн өмчлөгч: Гэр Интерьер Дизайн ХХК 36.4% Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид: Гэр Интерьер Дизайн ХХК 36.4% Л.Чинбат 11.5% Г.Бат-Эрдэнэ 13.87% Ардын тэтгэврийн данс 12.77% Н.Мөнхнасан 10% 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 21/09 тоот тогтоолоор Г.Бат-Эрдэнийг Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд өөрчлөлт ороогүй. ТУЗ нь 2024 онд 1 удаа биечлэн хуралдаж, эчнээ хэлбэрээр 7 удаа санал хураасан ба нийт 11 асуудал шийдвэрлэсэн. Мөн компанийн Аудитын хороо, Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо, Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороод нийт 4 удаа хуралдсан.

6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Байхгүй
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	Компанийн эцсийн өмчлөгч: 36.4%-ийн хяналтын багц эзэмшигч “Гэр Интерьер Дизайн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянга 2024 оны 12 сарын 31-ний байдлаар компанийн нийт 6,000,000 ширхэг хувьцааг 1,156 хувь хүн, аж ахуй нэгж эзэмшиж байна. 5 хувь буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчид: 1. ГЭР ИНТЕРЬЕР ДИЗАЙН ХХК 36.4% - 2,183,978ш 2. Л.ЧИНБАТ 18.7% - 1,122,686ш 3. Г.БАТ-ЭРДЭНЭ 13.87% - 832,286ш 4. АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС ХХК 13.56% - 813,931 5. Н.МӨНХНАСАН 10% - 600,000
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээ хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	2024 онд нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
9	Ногдол ашгийн мэдээлэл
	Тэнгэрлиг медиа групп ХК-ийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны цар хүрээг тэлж байгаатай холбогдуулан 2025 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 25/03 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр гаргасан болно.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Тэнгэр ТВ буюу Про медиа нетворк нь 2024 онд явагдсан УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр “Мэтгэлцээн 2024” цуврал контентийг санаачлан хэрэгжүүлж, үзэгчдээс өндөр үнэлгээ авлаа. Нийт 30 мэтгэлцээний дугаар хийж, сошиал орчинд 20 сая гаруй хандалтыг цуглуулсан бөгөөд энэ нь иргэдийг зөв сонголт хийхэд нөлөөлөл үзүүлэв. Сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд явагддаг хамгийн том арга хэмжээ “Алтан үзэг 2024” наадамд TenGer TV, Unread Media компаниуд мэдээллийн ивээн тэтгэгчээр ажиллалаа. Unread Media компани нь нийгмийн эерэг өөрчлөлтийг өртөөлж, залуусын оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг дэмждэг уламжлалтай. 2024 онд Хүний нөөцийн мэргэжилтнүүд болон талентуудыг холбох гүүр “Talent Summit”, Дата аналит, дата мэргэжилтнүүдэд зориулсан арга хэмжээ “Data Summit”, Медиа мэргэжилтнүүд, сонирхогчид болон олон нийтэд зориулсан талбар “The Media Show” зэрэг шинэ эвентийн цувралуудыг эхлүүлэв. Хамтрагч байгууллагуудын хамтаар зохион байгуулсан уг эвентүүд нь тухайн комьюнитигаас эерэг үнэлгээ авч чадлаа. Монгол ТВ нь 2024 оны их хурлын сонгуулын ажилтай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 11,101 секундын буюу 244 сая төгрөгийн цацалтыг хэвлэл мэдээллийг байгууллагын үүргийн дагуу, Соёл

урлагын газрын 10,805 секундын буюу 237 сая төгрөгийн цацалтуудыг цацсан.

Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлт Оргил цагаар мэдээлсэн.

Эрүүл мэндийн яамнаас Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг хорт зуршилгүй эрүүл ирээдүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд өсвөр үеийнхнийг хамгаалцгаая"сэдэвт хэлэлцүүлгийг Нийгмийн хүрээнд үнийн хөнгөлөлт үзүүлж Нүүдэл шийдэл нэвтрүүлгээр оруулсан болно.

Ори Студиос ХХК ийн хувьд Ургах наран хорооллын 200 р цэцэрлэгийн бяцхан сурагчдад оюуны хөрөнгө оруулалт болгон ном хандивлаж, хүүхдийн боловсрол, танин мэдэхүүд үнэтэй хувь нэмэр оруулаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 100 хүүхдэд өвлийн аялал, адал явдлаар дүүрэн дурсамж бүтээх боломж олгон Ори Винтер Паркын тасалбарыг бэлэглэсэн нь хүүхдүүдийн сэтгэл ханамж, баяр баяслыг бадраасан сайхан үйл явдал боллоо.

Ургах наран хорооллын эрчим хүчний дутагдалтай нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд, өндөр хүчдэлийн эрчим хүчний эх үүсвэрийг авчирч, оршин суугчдын амьдрах орчин, хэрэглээг сайжруулахад бодитой хувь нэмэр үзүүлэв.

Баянзүрх дүүргийн 11-р хорооны жилийн тайлангийн үйл ажиллагааг Ори Студи-д амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, олон нийтийн хамтын ажиллагаа, ил тод байдлыг хангахад хувь нэмрээ оруулаа.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг огноо:

Овог, нэр:

Албан тушаал "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн
Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)



Овог, нэр:

Албан тушаал: "Хүлэгт Хүннү Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Н.Гүррагчаа

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Э. Халиунгоо

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Халиунгоо

Гарын үсэг:

Э. Халиунгоо